



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 12 сарын 14 өдөр

Дугаар 608

Улаанбаатар хот

Төрийн өмчид эд хөрөнгө бүртгэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйл, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалт, Говь-Алтай аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн 2021 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн 26 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Говь-Алтай аймгийн өмчөөс шилжүүлсэн 7 нэрийн, нийт 400,352,595.72 (дөрвөн зуун сая гурван зуун тавин хоёр мянга таван зуун ерэн таван төгрөг далан хоёр мөнгө) төгрөгийн балансын үнэ, 183,279,912.20 (нэг зуун наян гурван сая хоёр зуун далан есөн мянга есөн зуун арван хоёр төгрөг хорин мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг төрийн өмчид хүлээн авч Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Говь-Алтай аймгийн Онцгой байдлын газрын хөрөнгөд бүртгэж, эзэмшүүлсүгэй.

2. Онцгой байдлын ерөнхий газрын дарга, хошууч генерал Г.Ариунбуян, Говь-Алтай аймгийн Онцгой байдлын газрын дарга, хурандаа З.Баттулга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Комисс томилон хөрөнгө хүлээн авч, бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2022 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132006976

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ӨМЧӨӨС ТӨРИЙН ӨМЧИД ХҮЛЭЭН АВЧ ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН
ГАЗАРТ ЭЗЭМШҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААТ

д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ (төгрөг)	Нийт үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
Барилга байгууламж								
1	Цогт сумын Эрүүл мэндийн төвийн хуучин барилга	1988.01.01	ш	1	351,420,051.72	351,420,051.72	144,870,878.36	206,549,173.36
2	Хашаа	2015.12.30	ш	1	17,291,744.00	17,291,744.00	9,699,833.84	7,591,910.16
3	Галалгааны байр	2005.01.01	ш	1	28,660,900.00	28,660,900.00	28,660,900.00	-
4	Сүүдрэвч	1990.01.01	ш	1	11,600.00	11,600.00	11,600.00	-
5	Зүлэгжүүлсэн талбай	1990.01.01	ш	1	18,000.00	18,000.00	18,000.00	-
6	Бохирын шугам	1988.01.01	ш	1	18,700.00	18,700.00	18,700.00	-
хэсгийн дүн				6		397,420,995.72	183,279,912.20	214,141,083.52
Биет бус хөрөнгө								
7	Газар эзэмших эрх (Цогт сум 4-р баг Хуучин эрүүл мэндийн төвийн газар)	2021.04.05	м.кв	2,443	1,200.00	2,931,600.00		2,931,600.00
хэсгийн дүн						2,931,600.00	-	2,931,600.00
Нийт дүн						400,352,595.72	183,279,912.20	217,072,683.52
						(дөрвөн зуун сая гурван зуун тавин хоёр мянга таван зуун ерэн таван төгрөг далан хоёр мөнгө)	(нэг зуун наян гурван сая хоёр зуун далан есөн мянга есөн зуун арван хоёр төгрөг хорин мөнгө)	(хоёр зуун арван долоон сая далан хоёр мянга зургаан зуун наян гурван төгрөг тавин хоёр мөнгө)